



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:[gonchigdorjuranbayr@gmail.com](mailto:gonchigdorjuranbayr@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<u>4</u>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	<u>5</u>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<u>6</u>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<u>7</u>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	<b>16</b>

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 117  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛДАРХААН СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
М.ДАГИЙ-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Алдархаан сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 611.8 сая төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 60.9 сая төгрөг, үнэ төлбөргүй орлого 141.7 сая төгрөгийн, нийт 814.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Алдархаан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцож олгосон, жолоочийн тооцоо буруу бодож шатахуун олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоолоогүй, зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй зэрэг асуудлууд байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

013070199

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>59,731,074.03</u></b>	<b><u>103,295,528.71</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	12,634,792.14	40,605,202.46
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	12,634,792.14	40,605,202.46
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	12,634,792.14	40,605,202.46
31211	Төрийн сангийн харилцах	11,705,863.52	39,676,273.84
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	928,928.62	928,928.62
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	10,717,808.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	10,717,808.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	47,096,281.89	51,972,518.25
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,500,000.00	2,500,000.00
35130	Эм боох материал	2,500,000.00	2,500,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	705,000.00	705,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	43,891,281.89	48,767,518.25
35410	Бичиг хэргийн материал	127,000.00	265,300.00
35420	Аж ахуйн материал	4,918,162.00	5,085,662.00
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	535,338.30
35450	Барилгын засварын материал	860,000.00	860,000.00
35460	Хүнсний материал	5,828,440.01	2,202,714.01
35470	Бусад хангамжийн материал	30,157,679.88	39,818,503.94
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,271,323,978.45</u></b>	<b><u>1,354,343,920.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,271,323,978.45	1,354,343,920.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,258,455,978.45	1,341,475,920.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,264,882,189.00	1,391,682,208.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-210,763,049.09	-229,200,136.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,826,322.60	87,826,322.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,620,034.62	-35,596,647.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,921,060.99	193,729,060.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,398,811.27	-88,879,038.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,311,059.35	40,031,059.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,899,091.98	-18,189,241.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	620,000.00	620,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-423,666.53	-547,666.49
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,868,000.00	12,868,000.00
39301	Програм хангамж	1,008,000.00	1,008,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,008,000.00	-1,008,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,868,000.00	12,868,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,331,055,052.48</u></b>	<b><u>1,457,639,449.67</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>55,924,478.13</u></b>	<b><u>65,497,429.73</u></b>

<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	55,924,478.13	65,497,429.73
<b>413</b>	<b>Өглөг</b>	55,924,478.13	65,497,429.73
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	55,679,127.33	65,497,429.73
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,275,130,574.35</b>	<b>1,392,142,019.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,275,130,574.35	1,392,142,019.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,708,260.50	150,708,260.50
51101	Өмч: - төрийн	150,708,260.50	150,708,260.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	938,773,125.70	1,055,784,571.29
51210	Өмнөх үеийн үр дүн	984,827,446.22	984,827,446.22
51220	Тайлант үеийн үр дүн	-46,054,320.52	70,957,125.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	185,649,188.15	185,649,188.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,331,055,052.48</b>	<b>1,457,639,449.67</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>611,732,789.61</b>	<b>814,568,577.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>61,668,089.61</b>	<b>141,790,204.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	26,669,765.61	141,790,204.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,669,765.61	141,790,204.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,669,765.61	141,790,204.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>550,064,700.00</b>	<b>672,778,372.77</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,661,000.00	36,992.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,661,000.00	36,992.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,116,700.00	60,948,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,116,700.00	60,948,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	507,287,000.00	611,792,780.77
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	611,792,780.77
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>642,477,639.51</b>	<b>697,557,131.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>642,477,639.51</b>	<b>697,557,131.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	642,477,639.51	696,384,530.45
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	331,261,973.83	411,122,488.46
210101	Үндсэн цалин	331,261,973.83	411,122,488.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,439,240.55	45,871,421.19
210201	Тэтгэврийн даатгал	37,439,240.55	45,871,421.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,681,236.66	66,834,750.87
210301	Гэрэл, цахилгаан	2,965,478.86	2,329,548.47
210302	Түлш, халаалт	60,715,757.80	64,505,202.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,682,300.00	32,836,211.70
210401	Бичиг хэрэг	1,675,600.00	1,661,700.00
210402	Тээвэр, шатахуун	21,576,900.00	23,964,661.70

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,000.00	2,057,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	608,000.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,945,800.00	4,802,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>90,452,494.79</b>	<b>61,638,990.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,605,769.79	43,864,264.00
210502	Хоол, хүнс	9,131,725.00	15,475,726.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	715,000.00	2,299,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,092,950.00</b>	<b>7,766,950.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,823,500.00	197,000.00
210604	Урсгал засвар	7,047,950.00	7,569,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,546,900.00</b>	<b>1,826,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,546,900.00	1,826,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,600.00</b>	<b>588,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210807	Газрын төлбөр	00.00	48,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>76,295,943.68</b>	<b>67,899,718.23</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,832,784.00	11,591,641.74
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,463,159.68	56,308,076.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>1,172,601.53</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,172,601.53</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,172,601.53
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-30,744,849.90</b>	<b>117,011,445.59</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-46,054,320.52</b>	<b>117,011,445.59</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>634,668,100.00</b>	<b>662,060,564.77</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,668,100.00</b>	<b>662,060,564.77</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,661,000.00	36,992.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,661,000.00	36,992.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,116,700.00	60,948,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,116,700.00	60,948,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	591,890,400.00	601,074,972.77
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	84,603,400.00	601,074,972.77
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>572,354,161.84</b>	<b>621,065,754.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>572,354,161.84</b>	<b>621,065,754.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>572,354,161.84</b>	<b>619,732,380.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	324,177,894.09	405,152,449.23
210101	Үндсэн цалин	199,294,965.01	279,913,100.03

210102	Нэмэгдэл	89,856,758.09	107,754,023.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,799,000.00	4,379,000.00
210104	Урамшуулал	30,227,170.99	13,106,325.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,277,969.49</b>	<b>51,590,411.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,463,869.49	33,741,111.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,453,600.00	5,920,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,962,700.00	3,296,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	490,400.00	960,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,907,400.00	7,671,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,116,700.00</b>	<b>56,855,676.03</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,085,116.60	2,168,776.03
210302	Түлш, халаалт	39,031,583.40	54,677,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	9,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,112,800.00</b>	<b>31,591,350.00</b>
210401	Бичиг хэрэг	1,718,600.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,576,900.00	22,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,000.00	2,057,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	608,000.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,333,300.00	4,884,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>72,056,002.00</b>	<b>58,013,264.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,350,077.00	43,864,264.00
210502	Хоол, хүнс	11,990,925.00	11,850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	715,000.00	2,299,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,971,450.00</b>	<b>7,851,950.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,823,500.00	197,000.00
210604	Урсгал засвар	5,926,450.00	7,654,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,546,900.00</b>	<b>1,826,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,546,900.00	1,826,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,600.00</b>	<b>648,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	60,000.00
210807	Газрын төлбөр	00.00	48,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,069,846.26</b>	<b>6,203,280.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,069,846.26	6,203,280.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>1,333,373.97</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>160,772.44</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	160,772.44
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,172,601.53</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,172,601.53
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>62,313,938.16</u></b>	<b><u>40,994,810.32</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>51,465,735.00</u></b>	<b><u>12,528,000.00</u></b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>51,465,735.00</b>	<b>12,528,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	51,465,735.00	12,528,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,465,735.00	12,528,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-51,465,735.00</b>	<b>-12,528,000.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	10,848,203.16	28,466,810.32
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,786,588.98	12,634,792.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,634,792.14	40,605,202.46

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,708,260.50	186,971,258.93	-40,291,644.29	297,387,875.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,708,260.50	186,971,258.93	-40,291,644.29	297,387,875.14
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-46,054,320.52	-46,054,320.52
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,708,260.50	185,649,188.15	938,773,125.70	1,275,130,574.35
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,708,260.50	185,649,188.15	938,773,125.70	1,275,130,574.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,708,260.50	185,649,188.15	938,773,125.70	1,275,130,574.35
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	117,011,445.59	117,011,445.59
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,708,260.50	185,649,188.15	1,055,784,571.29	1,392,142,019.94

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алдархаан сумын Эрүүл мэндийн төв нь Таны төлөө амьдралын итгэлтэй туслагч. Таны төлөө амьдралын итгэлтэй туслагч. Таны бие сэтгэлийг эмчилж чанартай амьдралыг бий болгоно гэсэн зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын ЭМТ-ийн дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна.

Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,472.57 мянган төгрөгөөр буюу 5,4 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	47,096.28	51,972.52	-4,876.24
Үндсэн хөрөнгө	1,271,323.98	1,354,343.92	-83,019.94
Нийт хөрөнгө	1,331,055.05	1,457,639.45	126,584.40
Өр төлбөр	55,924.48	65,497.43	-9572.9516
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,275,130.57	1,392,142.02	117,011.45
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,331,055.05	1,457,639.45	126,584.40

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 47,096.28 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 97,932.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй 14,990.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж

зарцуулсан 108,046.5 мянган төгрөг, акталсан бараа материал байхгүй бараа материалын эцсийн үлдэгдэл 51,972.52 мянган төгрөг болж өмнөх оноос 4,876.24 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 139,328.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, актласан үндсэн хөрөнгө байхгүй байна. Жилийн эцэст 1,354,343.92 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 56,308.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 126,584.40 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 619,837.0 мянга, нийт зарлагыг 619,837.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 601,074.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 556,139.7 мянган төгрөг буюу 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>71602</b>	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>				
80302	Нэг иргэнд ногдох нормативаар	477,402.60	426,351.50		<b>90%</b>
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	129,904.40	117,258.20		<b>94%</b>
83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	12,530.00	12,530.00		<b>100%</b>
	<b>Нийт дүн</b>	<b>619,837.00</b>	<b>601,074.9</b>		<b>89.7%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж 60,948.6 мянган төгрөг тогтмол зардалд зарцуулсан байна.

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
<b>71602</b>	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>				
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	60,948.60	60,948.60		<b>100.00%</b>
<b>НИЙТ</b>		<b>60.948.6</b>	<b>60.948.6</b>		<b>100.00%</b>

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/Мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1		бичиг хэрэг	1,400.00	2,606.15
2	Харьцуулалтын арга	тээвэр шатахуун	22,000.00	12,455.38
3	Харьцуулалтын арга	шуудан холбоо	980.00	1,978.40
4	Харьцуулалтын арга	хог хаягдал	1,200.00	1,198.00
5	Харьцуулалтын арга	бага үнэт түргэн элэгдэх	1,100.00	1,410.85
5	Шууд гэрээ байгуулах	эм бэлдмэл	36,000.00	29,113.72
6	Шууд гэрээ байгуулах	хоол хүнс	4,800.00	10,096.14
7	Шууд гэрээ байгуулах	нормын хувцас	1,600.00	2,037.00
8	Шууд худалдан авалт	Урсгал засвар	2,400.00	1,663.31
9	Шууд худалдан авалт	багаж техник	3,300.00	816.50
10	Шууд худалдан авалт	томилолт	3,440.00	2,624.70
11	Шууд худалдан авалт	Аудит	540.00	540.00
12	Шууд худалдан авалт	даатгал	60.00	60.00
	<b>ДҮН</b>		<b>87,647.00</b>	<b>74,479.53</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алдархаан сумын Эрүүл мэндийн төв 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан

толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 13 -ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 245,750.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,686.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,764.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоож 2023 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 699,557.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,463.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 7,870.0 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Алдархаан сумын Эрүүл мэндийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 91,422.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 955.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг хугацаанд барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	955.4	1	955.4	100
Албан шаардлага	1	91,422.9	1	91,422.9	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>92,378.3</b>	<b>2</b>	<b>92,378.3</b>	

#### **Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг тодохойлоогүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 17,923.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,052.6 мянган төгрөгийн алдааг залруулж 5,841.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж 2,029.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт хүргүүллээ.

**5.1** Аудитаар 10,052.6 мянган төгрөгийн залруулга хийлгэлээ.

#### **5.2 Албан шаардлага**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5,841.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

#### **5.3 Төлбөрийн акт**

Илүү цаг буруу тооцоолж олгосон 2,029.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

#### **5.4 Зөвлөмж хүргүүлээгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримт бүрдэл дутуу	1	5,841.1			1	5,841.1						
Илүү цаг буруу тооцож олгосон	1	2,029.3	1	2,029.3								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>7,870.4</b>	<b>1</b>	<b>2,029.3</b>	<b>1</b>	<b>5,841.1</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	10,052.6			1	10,052.6	1	10,052.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,052.6</b>			<b>1</b>	<b>10,052.6</b>	<b>1</b>	<b>10,052.6</b>				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х. БОЛДБААТАР

ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР



Ц. ОЮУНСУВД

ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР



Г. УРАНБАЯР

ОГНОО: 2024-02-22